

**МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ**  
**ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ**

№ 16/438

ШУС, НУС

2015

**ТЕЛЕВИЗИЙН МЭДЭЭНИЙ ЭХ СУРВАЛЖИД ХИЙСЭН**  
**АЖИГЛАЛТ ДҮГНЭЛТ**

О.Бямбагэрэл\*

\* МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Нийгмийн ухааны салбарын Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн магистрант

**Түлхүүр үг:** уламжлал ба уламжлалт бус эх сурвалж, мэдээллийн тэнцвэрт байдал, олон ургальч үзэл, эх сурвалжийн түвшин, брифинг, пресс-релиз

**С**этгүүл зүйд “эх сурвалж” хэмээх ойлголт онол, практик, арга зүйн хувьд онцгой үүрэгтэй бөгөөд үүнийг өргөн ба явцуу утгаар авч үздэг. Өргөн утгаар нь эх сурвалж гэдэг бол бидний эргэн тойронд, дэлхий дахинд өдөр тутам болж байгаа үйл явдал, үзэгдэл, баримт юм. Явцуу утгаар нь тухайн сэтгүүлчийн ямар нэг мэдээ материал бичихийн тулд баримт, мэдээлэл олж авсан тэр эх үүсвэр мөн. Ямар ч сэтгүүлч тухайн нийтлэл, нэвтрүүлгийг аль бичлэгийн төрлөөр бичихээс нь үл шалтгаалан олж авсан тодорхой баримтад үндэслэн бэлтгэдэг. Товчоор хэлбэл, нийтлэлийн үндэс суурийг бүрдүүлж буй тэр зүйлийг эх сурвалж гэдэг.

Мэдээллийн эх сурвалжийн талаар сэтгүүл зүй судлаачид янз бүрийн тодорхойлолт өгч, төрөл хэлбэрүүдэд ангилсан байдаг. Америкийн судлаач Мелвин Менчер: “Материалыг бичихэд мэдээллийн үндэс болж буй хүн,

баримт, үйл явдал”<sup>1</sup> гэсэн бол Херберт Стренц эх сурвалжийг уламжлалт ба уламжлалт бус гэж ангилаад “уламжлалт бус мэдээллийн эх сурвалжид урьд нь ихэвчлэн хөндөгдөж байгаагүй, эсхүл цаг үеэ даган шинээр бий болсон, олон нийтийн анхаарлаас гадуур байсан үйл явдал, асуудлуудын тухай мэдээлэл”-ийг багтаажээ<sup>2</sup>. Судлаач Т.Оюунбилэг: “Эх сурвалж гэдэг бол тодорхой нийтлэл, нэвтрүүлгийн эх үндэс болсон үйл явдал, ярилцлага, ажиглалт, туршилтын аргаар олж авсан баримт, эсхүл мэдээлэл бүхий хүн мөн. ...Мэдээллийн эх сурвалж бол аливаа үйл явдал, үзэгдлийн талаарх чухал, шаардлагатай мэдээллээр сэтгүүлчийг хангаж байдаг обьектив (баримт, материаллаг орчин) ба субъектив (хүн) хүчин зүйл юм”<sup>3</sup> гэж тодорхойлжээ. Энэ бүхнээс үзэхэд эх сурвалж гэдэг нь сэтгүүл зүйн аливаа бүтээлийн үндсийг бүрдүүлж буй мэдээллийг агуулж буй баримт, үйл явдал, хувь хүн гэдэг нь тодорхой байна.

Судлаачид мэдээллийн эх сурвалжийг агуулж буй мэдээллийн онцлог, зорилго, давтамж, ажиглаж байгаа байдал, баримтын онцлог зэргийг харгалзан янз бүрээр ангилсан байдаг. Америкийн зарим судлаач эх

сурвалжийг уламжлалт ба уламжлалт бус гэж ангилаад ОНМХ-ийн мэдээлэл, олон нийттэй харилцах албад, мэдээлэл баримт агуулж буй тодорхой багууллагууд, албан ёсны үйл явдал зэргийг уламжлалт эх сурвалжид, урьд өмнө хөндөгдөж байгаагүй, эсвэл цаг үеэ дагаад шинээр бий болсон, олон нийтийн анхаарлын гадуур байсан үйл явдал, үзэгдэл, асуудлын тухай мэдээллийг уламжлалт бус эх сурвалжид багтаадаг<sup>4</sup> байна. Үүнийг судалгааны зарим бүтээлд нээлттэй, хагас нээлттэй, хаалттай эх сурвалж гэж нэрлэсэн байдаг.

Нээлттэй эх сурвалжид ОНМХ, Интернет, Фидодент, пресс-релиз, янз бүрийн байгууллагын мэдээллийн албад, хэвлэлийн бага хурал, брифинг, нээлттэй шүүх хуралдаан, албан ёсны танилцуулга, сэтгүүлчдийг хамааруулдаг хагас нээлттэй эх сурвалжид бүх нийтийн хүртээл болоогүй, тэгсэн атлаа ямар нэг аргаар гарт орсон чухал баримт бичиг, фото зураг, гар бичмэл, хувь хүнээс тохиолдлын чанартай сонссон мэдээлэл багтдаг байна. Хагас нээлттэй эх сурвалж ямагт албан ёсны бус, тодорхой ХМХ-д зориулаагүй шинжтэй байдаг бөгөөд түүнийг хоёрдогч, гуравдагч эх сурвалжаар зайлшгүй баталгаажуулах шаардлагатай юм.

Хаалттай буюу нууц эх сурвалж гэдэг нь сэтгүүлч болгон нэвтрээд байдаггүй, олны хүртээл болох ёсгүй нууц мэдээллийг тээгч хүн, эсвэл тодорхой нэг объект мөн. Ийм эх сурвалжуудыг шинж чанарыг харгалзан амьд ба амьгүй, давтамжийг харгалзан байнгын ба нэг удаагийн, ашигласан байдлаар нь анхдагч ба хоёрдогч, хүлээж авч буй байдлаар нь аман ба бичгийн, цахим гэж ангилдаг байна<sup>5</sup>.

Янз бүрийн хүмүүстэй ярилцах, асуулт тавих, санал солилцох замаар

олж авсан мэдээллүүд аман эх сурвалжид багтдаг. Амьгүй эх сурвалж гэдэг нь тодорхой мэдээллийг агуулж буй янз бүрийн байгууллага, мэдээллийн бааз, бүх төрлийн баримт бичгүүд, утсан ба цахим холбооны сүлжээгээр дамжуулсан мэдээлэл юм.

**С**этгүүл зүй нь бүхэлдээ баримтын эрэл, түүнийг мэргэжлийн түвшинд бүрдүүлж боловсруулах судалгаа юм. Сэтгүүлч баримтыг хий хоосон зүйлээс гаргаж ирдэггүй бөгөөд судалгаа сурвалжлага хийх явцдаа олж мэдсэн, сонсож дуулсан, эсвэл үзэж харсандаа тулгуурлан сэтгүүл зүйн бүтээл туурвидаг. Тэрхүү баримт мэдээллийн аливаа эх үүсвэр нь сэтгүүл зүйн эх сурвалж гэсэн ойлголтонд хамаарна. Өөрөөр хэлбэл “Баримтыг бодит мэдээлэл болгож, түүний үнэ цэн, ач холбогдлыг тодорхойлж, хүлээн авагчдын сэтгэл зүйд нөлөөлөх чадварыг дээшлүүлдэг гол хүчин зүйл бол эх сурвалж юм”<sup>6</sup>. Энэ утгаар авч үзвэл сэтгүүл зүйн бүтээлийн амин сүнс нь эх сурвалж юм. Телевизийн мэдээний эх сурвалж нь гол төлөв аман эх сурвалж байна. Онолын хувьд аман эх сурвалжийг мэдээллийг үнэлж, цэгнэх, үнэлэмжийн түвшингээр нь гурав ангилдаг. Энэ бол:

- Мэргэжлийн түвшин – тухайн асуудлыг хөндлөнгийн мэргэжилтний байр сууринаас хандан тайлбарлана.

- Сонирхлын түвшин – тухайн асуудалд эрх ашгийн үүднээс хандах тул хамгаалсан байр суурь илэрхийлнэ.

- Үр дагавар хүртэгсдийн түвшин – тухайн асуудалд шууд хамаатай, эрх ашиг нь хөндөгдсөн талууд юм.

Үзэгч, сонсогч, уншигчдын итгэл үнэмшлийг төрүүлж, сэтгүүл зүйн бүтээлийн олон нийтэд нөлөөлөх чадварыг дээшлүүлдэгт эх сурвалжийн үнэ цэн оршино. Тэр дундаа мэдээлэл,

нийтлэл нэвтрүүлгийн төрөл зүйлийн нэг болсон телевизийн мэдээнд эх сурвалж онцгой чухал гэдэг нь тодорхой. Эх сурвалжгүй мэдээ сэтгүүл зүйн алтан зарчим болсон тэнцвэрт, үнэн бодит байдлыг хангаж чадахгүй. Үүнээс үзэхэд телевизийн сайн мэдээний чанарын нэг гол шалгуур нь эх сурвалж болдог.

**М**эдээ, сурвалжлаганд хэдий чинээ олон талын эх сурвалжийг ашиглаж, мэдээллээ баяжуулна, төдий чинээ үзэгчдэд хүртээмжтэй тэнцвэртэй мэдээ хүрнэ. Харин манай телевизүүдийн мэдээнд эх сурвалжийн ашиглалт тааруу, асуудал хөндсөн мэдээ сурвалжлагад ганцхан эх сурвалж ашиглаж байгаагаас мэдээллийн тэнцвэрт байдал алдагдаж байгаа нь түгээмэл ажиглагдаж байна. Жишээ дурдъя.

МҮОНРТ-ийн ММ агентлагийн бэлтгэн хүргэдэг “Цагийн хүрд” мэдээллийн хөтөлбөрт эх сурвалжаас үүдэлтэй “усан” мэдээ бэлтгэгдэн олон нийтэд хүрч, мэдээллийн хөтөлбөрийн ач холбогдлыг бууруулж байгаа тохиолдол цөөнгүй байна. 2015 оны 3-р сарын 26-ны 20.00 цагийн мэдээллийн хөтөлбөрт орсон сэтгүүлч Б.Пүрэвийн бэлтгэсэн “Энэ намар зургаан настнууд сургуульд хэрхэн хамрагдах вэ?” гэсэн сэдэвтэй бичил сурвалжлага зөвхөн нэг талын эх сурвалжийг ашигласан “усан” сурвалжлагын нэг юм. Уг сурвалжлагад нэг талын эх сурвалж буюу төрийн байгууллагыг төлөөлж БШУЯ-ны газрын дарга Б.Гантулгаас цэцэрлэгийн хүртээмжийн талаар ярилцлага авсан. Ингэж асуудал хөндсөн сурвалжлагад зөвхөн нэг талын эх сурвалж ашиглаж байгаа нь мэдээллийн багтаамж, тэнцвэрт байдлыг алдагдуулж байна. Учир нь сургууль цэцэрлэгийн хүрэлцээний

асуудалд үр дагаврыг хүртэгсдийн түвшин буюу үүнд шууд хамаатай, эрх ашиг нь зөрчигдөж байгаа хүүхдүүдийн эцэг эх, багш нараас ярилцлага авч тэднийг анхдагч эх сурвалжаа болгох ёстой байсан. Ингэснээр мэдээллийн тэнцвэрт байдал хангагдаж, үнэ цэн, багтаамж дээшилж, үзэгчдийн сэтгэл зүйд илүү хүчтэй нөлөөлөх болно. Мөн ММ агентлагийн мэдээнд гол төлөв төр засгийн эх сурвалж зонхилж байгаа нь мэдээллийг сонирхолгүй, уйтгартай, хэт албаны шинжтэй болгох тохиолдол элбэг байна. Гэхдээ нэг талын эх сурвалжийг ашигладаг дутагдал бусад арилжааны телевизүүдтэй харьцуулахад ММ агентлагийн мэдээнд харьцангуй бага гарч байна. Тухайн өдрийн гол мэдээ, сурвалжлагад аль болох олон талын эх сурвалжийг ашиглаж, мэдээллийн тэнцвэрт байдлыг хадгалж чадсан сайн жишээ ММ агентлагийн мэдээллийн хөтөлбөрт цөөнгүй байна. Тухайлбал, 2015 оны 4-р сарын 5-ны өдрийн мэдээллийн хөтөлбөрт орсон сэтгүүлч Б.Ариунцэцэгийн “Ургах наран” хорооллын бохир хальж байна” нэртэй сурвалжлага бүх талын эх сурвалжийг багтаасан сайн сурвалжлага болжээ. Тус сурвалжлагын эхний эх сурвалж нь эрх ашиг нь хөндөгдсөн “Ургах наран” хорооллын оршин суугчид, хоёр дахь эх сурвалж нь уг асуудалд хариулт өгөх “Ургах наран” хорооллын бохирын асуудал хариуцаж байгаа компанийн төлөөлөл, гурав дахь эх сурвалж нь “Ургах наран” хорооллын бохирын асуудлыг шийдвэрлэх учиртай нийслэлийн удирдлагыг багтаасан нь мэдээллийн үнэ цэнийг нэмэгдүүлж мэдээллийн тэнцвэрт байдлыг хангасан, итгүүлэн үнэмшүүлэх чадвар сайтай сурвалжлага болжээ. Үүнээс эх сурвалжийг хэрхэн ашиглаж, олж илрүүлэхээс

тухайн мэдээний үнэ цэн шалтгаалж, сайн эсвэл муу мэдээ болох уу? гэдэг хамаарч байгаа нь харагдаж байна. Гэхдээ эх сурвалжийг чадварлаг ашиглаж, сэтгүүлч эрэл хайгуул хийж, баримтыг эх сурвалжаар баталгаажуулсан мэргэжлийн түвшний “бүрэн гүйцэд” мэдээ, сурвалжлага манай телевизүүдийн мэдээллийн хөтөлбөрт өдрийн од шиг ховор байгааг хэлэх хэрэгтэй. Гол төлөв “хагас дутуу” мэдээ буюу сэтгүүлч олсон баримтаа эх сурвалжаар баталгаажуулж чадаагүй гүйцэтгэл муу, боловсруулалт тааруу мэдээ сурвалжлага зонхилж байна. Арилжааны телевизүүдийн нэг болох ETV-HD телевизийн мэдээллийн хөтөлбөрт тухайн өдрийн хамгийн дуулиан шуугиантай мэдээ эх сурвалжгүй байж, сэтгүүлч эх сурвалжийн дүрд өөрөө тоглож “стэнд-ап” хийж мэдээ бэлтгэх, асуудал хөндсөн сурвалжлагад зөвхөн нэг талын эх сурвалж ашиглах, хэн нэгний сонин, мэдээллийн сайтад өгсөн ярилцлагыг ашиглахдаа эх сурвалжаа дурдахгүй байх гэх мэтийн алдаа дутагдал түгээмэл гарч байгаа нь үүний тод жишээ юм. 2015 оны 3-р сарын 27-ны өдөр сэтгүүлч Ц.Цогтбаярын бэлтгэсэн “МИАТ-ын экс удирдлагууд ялаас чөлөөлөгдлөө” гэх тухайн өдрийн хамгийн дуулиантай мэдээ ямар ч эх сурвалжгүй байна. Харин сэтгүүлч өөрөө эх сурвалжийн үүрэг гүйцэтгэх буюу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын гадаа хөтлөлт хийж, тус байгууллагаас өгсөн мэдээллийг сэтгүүлч дамжуулах төдий өнгөрсөн.

Гэсэн ч энэ нь үзэгчдэд итгэл төрүүлэх баттай эх сурвалж болж чадахгүй гэдэг нь ойлгомжтой юм.

Мөн манай телевизүүдийн мэдээнд эх сурвалжийн сонголт, ашиглалт тааруу байгаа нь түгээмэл ажиглагддаг дутагдлын нэг юм. Эх сурвалжаа зөв сонгох нь сэтгүүлчийн мэдлэг мэдрэмж, ур чадвартай шууд холбоотой. Эх сурвалжаа хэр зөв сонгосноос шалтгаалж мэдээллийн үнэ цэн хэмжигдэж,

мэдээллийн хүртээмж тодорхойлогдоно. Өөрөөр хэлбэл тухайн асуудлын талаар хамгийн сайн мэддэг хүнээс ярилцлага авч ашиглахаас гадна олон нийтэд үнэлэгддэг, олны танил хүмүүсийг эх сурвалжаа болгон ашиглах нь тухайн мэдээний хүртээмж буюу олон

«  
***Манай телевизүүдийн мэдээнд  
эх сурвалжийн сонголт,  
ашиглалт тааруу байгаа нь  
түгээмэл ажиглагддаг  
дутагдлын нэг юм. Эх  
сурвалжаа хэр зөв сонгосноос  
шалтгаалж мэдээллийн үнэ цэн  
хэмжигдэж, мэдээллийн  
хүртээмж тодорхойлогдоно***  
»

нийтэд хүрэх байдалд чухал үүрэгтэй юм. Түүнчлэн асуудлын учир шалтгааны голыг олоход эх сурвалж сэтгүүлчдэд тусалдаг. Манай телевизүүдийн мэдээнд олон талын эх сурвалж ашиглаж, асуудлын учир шалтгаан, зангилаа, үр дагаврыг гаргаж байгаа мэдээ сурвалжлага маш ховор байна.

Харин алдарт ВВС-ийн сэтгүүлчид баримтыг эх сурвалжаар баталгаажуулах чадварыг сайн эзэмшсэн бөгөөд тэр хэрээр “амттай” сурвалжлага бэлтгэж чадаж байна. Тухайлбал, ВВС-ийн 2014 оны 3-р сарын 31-ний 18.00 цагийн мэдээллийн хөтөлбөрөөр багш нар талбай дээр ажил хаясан тухай сурвалжлага гарч байна. Ийм үйл явдал манай улсад ч олон болдог. Энэ төрлийн мэдээг манай мэдээний ихэнх сэтгүүлч хийхдээ жагсаал дээр очин

багш нараас ярилцлага авч ганцхан талын эх сурвалжийг ашиглан телевизээр нэвтрүүлдэг. Харин ВВС-ийн сэтгүүлч тэгсэнгүй. Багш нар ажил хаясан сурвалжлагын анхдагч эх сурвалж нь ажил хаялтаас хохирсон сурагчид болон эцэг эхчүүд. Сэтгүүлч нэгдүгээрт, сурагчид эцэг эхчүүдээс ярилцлага авч тэдний байр суурийг гаргасны дараа ажил хаяж байгаа багш нарыг хоёр дахь эх сурвалжаа болгосон. Үүний дараа асуудлын учир шалтгааны тайлахын тулд боловсролын сайдыг гурав дахь эх сурвалжаа болгон сонгосон. Эх сурвалжийг зөв сонгож, олон талт байр суурийг гаргаснаар тухайн материал сайн сурвалжлага болж олон нийтэд хүрдгийн тод жишээ энэ юм.

Дэлхий нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслийн тоо нэмэгдэж шинэ тутам мэдээлэл харилцааны хэрэгсэл үүсэн бий болохын хэрээр сэтгүүл зүйд ч мөн шинэ эх сурвалж бий болж байна. Сүүлийн үед дэлхий нийтэд нийгмийн цахим сүлжээ буюу фэйсбүүк, твиттер мэдээллийн хэрэгслийн үүргийг гүйцэтгэж олон нийт мэдээллийг хурдан шуурхай авч байна. Бүр зарим орон өөрийн бодлогыг гадаадад сурталчлах, бусдад тулган хүлээлгэх зорилгоор “Twitter”-ийг идэвхтэй ашиглаж байна. Жишээлбэл, хатагтай Хиллари Клинтон АНУ-ын Төрийн нарийн бичгийн даргын албыг хашиж байхдаа “Twitter”-ийг ардчиллыг экспортлох шинэ хэрэгсэл гэж албан ёсоор зарласан. Өөрөөр хэлбэл Америкийн бодлогыг түгээн дэлгэрүүлэх, сурталчлах хэрэгсэл гэсэн үг. Үүний дараа Америкийн сэтгүүлчид фэйсбүүк, тветтирийг эх сурвалж болгон мэдээ бэлтгэх тохиолдол эрс нэмэгдсэн байна.

Манай улсын хэвлэл мэдээллийн хэрэгсэлд ч сүүлийн үед сэтгүүлчид

фэйсбүүк, твиттерийг эх сурвалж болгон ашиглаж мэдээ, сурвалжлага бэлтгэж байгаа тохиолдол цөөнгүй байна. Тухайлбал, Ийгл телевизийн 2015 оны 9-р сарын 15-ны мэдээллийн хөтөлбөрөөр сэтгүүлч Алтанхүү “Өршөөлийн хуульд тавьсан Ерөнхийлөгчийн хоригийг УИХ-ын Хууль зүйн байнгын хороо гуйвууллаа” гэсэн сэдэвтэй мэдээ бэлтгэхдээ Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн өөрийн твиттер хуудаснаа “Хоригийн хэлбэрийг авлаа. Агуулгыг авсангүй. Хориг тойрох гэж хөгөө чирсээр...” гэх жиргээг ашиглаж, мэдээ бэлтгэсэн бөгөөд үүнээс УИХ-ын Хууль зүйн байнгын хороо Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авсангүй гэсэн дүгнэлт хийжээ. Өөрөөр хэлбэл шийдвэр гаргасан УИХ-ын гишүүдийн нэгнээс ч ярилцлага аваагүй мөртлөө Ерөнхийлөгчийн твиттерийн мэдээллийг ашиглаж, түүнийг эх сурвалжаа болгон мэдээ бэлтгэсэн нь учир дутагдалтай болжээ.

**И**йм байдлаар фэйсбүүк, твиттерийг эх сурвалж болгон ашиглаж байгаа тохиолдол сүүлийн үед телевизийн мэдээнд ч ихсэх хандлага ажиглагдаж байна.

Тухайлбал, 2015 оны 4-р сарын 21-нд УИХ-ын дарга З.Энхболд өөрийн твиттер хуудаснаа “Хоёр сая хувьцаа эзэмшигчээс санал аваагүй тул Тавантолгойн гэрээг засгийн газарт буцаалаа” гэж бичсэн жиргээ TV5, TV9, СтарТВ, Эх орон-ТВ, NTV, ETV зэрэг телевизийн ихэнх мэдээллийн хөтөлбөрт УИХ-ын дарга З.Энхболдын жиргээг мэдээ болон гарсан. Энэ бол УИХ-ын дарга З.Энхболдын өөрийн твиттер хуудаснаа бичсэн мэдээллийг УИХ-ын даргын үг буюу эх сурвалж болгон ашигласан гэсэн үг юм. Гэтэл твиттер, фэйсбүүкийн мэдээлэл бодит мэдээлэл биш албан ёсны эх сурвалж

болж чадахгүй гэдэг нь маргашгүй үнэн юм. Энэ нь ч амьдрал дээр батлагдсаар байна. Ром хотын нэгэн сургуульд ажилладаг утга зохиолын багш Томмассо де Бенедетти гэгч “Twitter” дээр дэлхийн нийтэд танил болсон аль нэгэн алдартай хүний өмнөөс хуудас нээдэг байна. Тэрээр Италийн Ерөнхий сайд, эсвэл Афганистаны Ерөнхийлөгчийн өмнөөс жиргэдэг хуудас анх нээсэн.

**У**далгүй тэдний нэрийн өмнөөс өөр бусад алдартнуудыг нас барсан тухай мэдээлээд гүн эмгэнэл илэрхийлдэг болжээ. Үр дүнд нь дэлхийн нийтийг хамарсан том дуулиан дэгдэн зарим газар үймээн самуун, зарим газар баяр хөөр болдог байв. Томмассо де Бенедетти нь цагтаа Жоан Роулинг, Михаил Горбачёв, Ромын пап XVI Бенедикт, Башар Асад зэрэг хүнийг нас барсан тухай мэдээ цацаж байсан хэргийн эзэн юм. Эдгээрээс болж гарсан нөлөө гэхэд янз бүр. Башар Асад нас барсан цуу “Twitter”-ээр тархсаны дараа дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнэ огцом өссөн. Үр дүнд нь газрын тос борлуулагчид гэнэтийн ашиг олж, худалдан авагчид “шатсан”. Томмассо де Бенедеттийн энэ мэтчилэн худал мэдээлэл тарааж байгаа үйл явдал олон нийтэд ил болсны дараа тэрээр “Гардиан” сонинд ярилцлага өгч, “Ямар нэг шунахайн сэдэл надад байгаагүй, зөвхөн “Twitter”-ийг л ямар ч найдваргүй шинэ мэдээний эх сурвалж болсон гэдгийг харуулахыг хүссэн. Мөн ийм эх сурвалжаас сэтгүүлчид шалгалгүйгээр шууд мэдээлэл авч байгааг харуулахыг зорьсон” гэж хэлсэн байна. Энэ бол нийгмийн мэдээллийн эх сурвалж ОНМХ-ийн хувьд хэзээ ч баталгаатай эх сурвалж болж чадахгүй гэдгийг харуулах баримт мөн.

Твиттерээр худал мэдээллийг тараах боломж нээлттэй буюу ийм төрлийн мэдээлэл үнэн бодит биш байх магадлал өндөр гэдэг нь тодорхой байтал манай сэтгүүлчид яагаад хэн нэгэн хүний твиттер хуудаснаа бичсэн “жиргээг” эх сурвалж болгон ашиглаж байна вэ? гэдэгт хэвлэл мэдээллийн байгууллагын удирдлага анхаарлаа хандуулах цаг болсон. Эх сурвалжийг нягтлаагүй, худал мэдээлэл аюулт тахлаас илүү нийгэмд хор хохирол дагуулдаг билээ.

### Ишлэл

- <sup>1</sup> *Менчер Мелвин*. 2001. Сэтгүүл зүйн бичлэгийн үндэс (Орч. Б.Агар нар). УБ., х. 496.
- <sup>2</sup> *Strentz Herbert*. 1992. News Reporters and News Sources. New Delhi, p. 124.
- <sup>3</sup> *Оюунбилэг Т.* 2007. Монголын сонины мэдээллийн эх сурвалжийн өнөөгийн байдал, тулгамдсан асуудлууд // Сэтгүүл зүйн докторын диссертаци. УБ., х.13.
- <sup>4</sup> *Strentz H.* New Reporters... p. 124.
- <sup>5</sup> *Зулькафиль М.* 2007. Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн онол, практик. УБ., х. 87-88.
- <sup>6</sup> *Зулькафиль М.* 2009. Сэтгүүлчийн ур чадвар-I. УБ., х. 36.

### Ашигласан бүтээлийн жагсаалт

1. NTV телевиз. Үндэсний мэдээ (“Үндэсний мэдээ” цахим хуудас).
2. *Strentz Herbert*. 1992. News Reporters and News Sources. New Delhi.
3. Глоб Интернэйшнл ТББ-ийн цахим хуудас
4. *Зулькафиль М.* 2007. Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн онол, практик. УБ.
5. *Зулькафиль М.* 2009. Сэтгүүлчийн ур чадвар-I. УБ.
6. *Менчер Мелвин*. 2001. Сэтгүүл зүйн бичлэгийн үндэс (Орч. Б.Агар нар). УБ.
7. МҮОНРТВ, ММ агентлаг мэдээ (www.mnb.mn)
8. *Оюунбилэг Т.* 2007. Монголын сонины мэдээллийн эх сурвалжийн өнөөгийн байдал, тулгамдсан асуудлууд // Сэтгүүл зүйн докторын диссертаци. УБ.

9. *Өнөрсайхан Т., Мэндхүү Г.* 2013. Телевизийн сэтгүүл зүй. УБ.

10. ТВ-5 телевиз. Цаг хөтөлбөр (www.tv.mn)

### **Резюме**

Автор, анализируя источники новостей информационных программ Монгольского национального общественного телевидения и коммерческих телевидений, пока-

зывает существующие недостатки в использовании разных источников информации. В результате анализа информационных программ телевидений автор сделал вывод о том, что односторонность, недостатки необходимых источников, использование неаргументированных фактов из социальных медиа негативно влияют на достоверность, балансируемость, доступность и действенность новостей информационных передач телевидений.